

Байгууллагын засвар тохижилт, бүтээн байгуулалтын ажил, хөрөнгө оруулалтын талаар хийсэн ажил, санхүүжилтийн эх үүсвэр, ахиц өөрчлөлт, үр дүн:

Сумын ЗДТГ-т хүргүүлсэн хүсэлтийн дагуу Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 04 сарын 19 –ны өдрийн 26 тоот тогтоолоор хөрөнгө балансаас баланс руу шилжих тухай шийдвэр гаргуулсан. Орон нутаг судлах танхимд их засвар хийлгэх талаар “Соёлын өвөө дээдлье” төсөл бичиж сумын удирдлагат хандаж шийдвэрлүүлэн тендер зарлагдаж ОНХСангийн 67 945 325 сая төгрөгний хөрөнгөөр “Өгөөмөр Бурхант” барилгын компани их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн



Уг ажлыг гүйцэтгэхэд тохижилтын зардлын тооцоо судалгаа гаргаж ажилласны хүчинд барилгын засвараас гарсан мод төмрийг зарж 1340,0 мян төг,иргэдийн хандиваар 800 000 мян төг, төсвөөс 2300 000 тус тус нийт 4400 000 мян төгрөгний зардалыг олж зохицуулан ажиллаа.



Үүний үр дүнд:

Орон нутаг судлах танхимын үзмэрийг дэглэж байрлуулах, дотоод эд хөрөнгийг угааж цэвэрлэх, будаж дотор оруулан , самбар хийх, будах, үзмэрт уут оёх , үзмэрийг кодлох , баярын бичиг он дарааллаар ялгаж уутлах , үзмэрийн суурь хийж , давуугаар бүрэх , сандалны хүрээ наах , хүндэтгэлийн өрөөнд суурь хийх гэх мэт ажлыг хамт олныхоо хүчээр хийж гүйцэтгэв.



Аймгийн музейн захирал Бямбажав, ажлын хэсгийг орон нутагтаа урьж МАА,угсаатны танхимын үзмэрийг гардан дэглэж мэргэжлийн зөвөлгөө өгч 2 өдөр хамтран ажиллаа. Энэ хугацаанд ахмад

настан Т.Гунгаа Ш.Болд Ж.Ганбат,Д.Маам,Б.Чимгээ,Сайхан дэлгэр, Т.Шонхор, Очирсайхан, ,Юмжир,Өлзий загд нар нь Т.Гунгаа, Ш.Болд, Очирсайхан, Ж.Ганбат, Д.Маам, Б.Чимгээ, Сайхан дэлгэр, Юмжир, Өлзий загд нар өөрийн гар байгаа мал ахуй холбогдолтой эд зүйлээ сэтгэл харамгүй өгч туслаж дэмжин ажиллаа.